

UCS 1506C:2020

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАР СТАНДАРТЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, БАТАЛГААЖУУЛАЛТ




Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага



ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАР СТАНДАРТЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, БАТАЛГААЖУУЛАЛТ

Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага



ГАРЧИГ

1. Зорилго	1
2. Хамрах хүрээ	1
3. Норматив эшлэл.....	1
4. Нэр томъёоны тодорхойлолт.....	1
5. Барилгын материалын чанарын үзүүлэлт.....	2
6. Барилгын гадна заслын материал.....	3
7. Гадна шавардлага, материалын шаардлага.....	5
8. Барилгын дотор засал, заслын материал.....	7
9. Цемент.....	11
10. Элс.....	11
11. Өнгөлгөө ба тэгшилгээний материал.....	11
12. Замаска.....	12
13. Ханын цаас.....	14
14. Будаг.....	18
15. Савалгаа, халгалалт тээвэрлэлт.....	21
16. Ашигласан материалын жагсаалт.....	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 6.1. Гадна заслын материал.....	4
Хүснэгт 7.1. Гадна фасадын шавардлагын материал.....	5
Хүснэгт 8.1. Дотор заслын шавардлагын материал.....	7
Хүснэгт 8.2.1. Шавардлага хийх технологи.....	8
Хүснэгт 8.3.1. Хуудсан материалаар өнгөлсөн буюу шавардсан гадаргуугийн хүлцэл.....	10
Хүснэгт 11.1. Өнгөлгөө тэгшилгээний материалууд.....	11
Хүснэгт 14.1. Будгийн гадаргууг бэлтгэх үе шат.....	19
Хүснэгт 15.1. Материалын хадгалах нөхцөл.....	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 5.1. Чанарын гэрчилгээ /Жишээ.....	3
Зураг 13.1. Ханын цаас наах дараалал.....	16
Зураг 13.2. Ханын цаасны цавуу түрхэх.....	16
Зураг 13.3. Ханын цаас наах технологи.....	17
Зураг 15.2. Заслын материалын агуулахад хадгалах.....	22
Зураг 15.3. Материалын савлагаан дахь сануулах тэмдэг тэмдэглээс.....	22

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАР СТАНДАРТЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, БАТАЛГААЖУУЛАЛТ

Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага

1. ЗОРИЛГО

Барилга байгууламжийн гадна болон дотор заслын хуурай ба нойтон шавардлага, будаг, цаасалгаа, өнгөлгөө, тэгшилгээ гэх мэт заслын ажлын гүйцэтгэл болон материалын чанарын шаардлагыг дээшлүүлэхэд энэхүү баримт бичгийн зорилго оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Барилга байгууламжийн дотор, гадна заслын материал сонгох, ашиглах, хадгалах тээвэрлэх явцад чанарыг алдагдуулахгүй байлгах үйл ажиллагаанд хамаарна.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, техникийн баримт бичгүүдийг иш татан хэрэглэсэн. Иш татсан стандарт, техникийн баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

3.1. MNS 3091:2008 “Цемент техникийн ерөнхий шаардлага”

3.2. MNS 0392:2014 “Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс”

3.3. MNS 6424 2013 “Барилгын ажилд хэрэглэх цавуу”

3.4. MNS 5079 2001 “Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрийн эрүүл ахуй. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”

3.5. MNS 0974:2008 “Портландцемент “Техникийн шаардлага”

3.6. MNS 5526 2005 “Барилгын заслын ажилд хэрэглэх замаск. Техникийн шаардлага.”

3.7. MNS 4583:2003 “Тосон будаг. Техникийн шаардлага ба турших арга”

3.8. MNS 5252:2003 “Барилгын ажилд хэрэглэх цийдмэг будаг. Техникийн шаардлага ба турших арга”

3.9. БНБД 31-10-05 “Заслын ажил”

4. НЭР ТОМЬЁО ТОДОРХОЙЛОЛТ

Цемент: барилгын элементүүдийг барьцалдуулагч материал;

Терразит зуурмаг: Барилгын талбай дээр хуурай хольцыг усаар зуурч гялтганасан чимэглэл оруулахын тулд гялтгануур нэмсэн зуурмаг;

Дотор шавардлага: Зуурмагийг гадаргууд цацаж тэгшилж, өнгөлж бэхжүүлсэн бүрхүүл үеийн шавардлага;

Замаск: Барилга байгууламжийн дотор болон гадна хана, таазны өө сэв дарах тэгшлэх, өнгөлөх заслын материал;

Ханын цаас: барилга байгууламжийн өрөө тасалгаанд өнгө нэмэх, өө сэвийг дарах, тав тухтай орчин бүрдүүлэгч ханын өнгөлгөөний материал;

Тосон будаг: Дан олифаар (хатаагч тос) найруулсан будаг;

Маркировки: Үйлдвэрлэгч тухайн материалын савлагаанд хадгалах нөхцөл, хэрэглээ, үйлдвэрлэсэн хугацаа, чанарын тэмдэг зэргийг тэмдэглэсэн тэмдэглээс;

Атмосфер: Дэлхийн татах хүчинд захирагдах агаарын даралтыг хэлнэ.

5. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

5.1.Барилгын чанар нь барилгын материалын чанараас шууд хамааралтай бөгөөд чанарын шаардлага хангасан талаар эрх бүхий байгууллагуудаас тохирлын үнэлгээний болон чанарын гэрчилгээ олгодог. Эдгээр гэрчилгээ бүхий барилгын материалыг сонгон хэрэглэх нь барилгын чанар аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болно. Үүнд:

Дараах хэд хэдэн чанар стандартын гэрчилгээ олгогч баталгаажуулалтын байгууллага байдаг.



Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 гэрчилгээ



Европын бүсэд зарагдаж буй бүтээгдэхүүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах стандарттай нийцэж буйг харуулсан тэмдэг



Европын барилгын салбарын Байгаль орчны бүтээгдэхүүний тунхаглалын тэмдэг



Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгогддог Америкийн бетоны институт



Стандартчилал хэмжил зүйн газрын MNS стандарт



APAC – Номхон далайн итгэмжлэлийн магадлал



Үндэсний итгэмжлэлийн төв бүтээгдэхүүний шалгалт тохируулга CL xxx



Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO14001:2015 гэрчилгээ



Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгогддог Америкийн тест ба материалын нийгэмлэгийн тэмдэг



Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын менежмент ISO45001 гэрчилгээ



Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгогддог Олон улсын барилгын код



ILAC MRA – Олон улсын лаборатори



Олон улсын итгэмжлэл



Үндэсний итгэмжлэлийн төв бүтээгдэхүүний лабораторийн сорилт TL xxx

5.1.1.Барилгын материалд чанарын гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, сорилт шинжилгээний дүнтэй байх ба түүнд дараах мэдээллүүд багтсан байна: Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр, хаяг,
- Материалын нэр, тэмдэглэгээ
- Материалын төрөл
- Нэмэлтийн төрөл, хэмжээ
- Сорилын үр дүн, огноо
- Баталгаат хугацаа, /сараар/
- Бүтээгдэхүүний тодорхойлолт
- Гэрчилгээний дугаар болон олгосон огноо



Зураг 5.1. Чанарын гэрчилгээ /Жишээ/

6. БАРИЛГЫН ГАДНА ЗАСЛЫН МАТЕРИАЛ

- 6.1.Барилгын материалыг үндсэнд нь органик (мод) ба органик бус гэж ангилна. Үүнээс гадна дахин ашиглах боломжтой ба боломжгүй (Хоёрдогч барилгын материал) гэж ангилдаг.
- 6.2.Барилга байгууламжийн бүтээц төлөвлөлт бүр өөр өөрийн онцлогтой байдаг тул түүнд тохирсон материалыг сонгон хэрэглэнэ.
- 6.3.Материалын үзүүлэлтүүд болон тэдгээрийг хэрэглэх дэлгэрэнгүй зөвлөмж, зааврыг үйлдвэрлэгчээс гаргасан байдаг бөгөөд заслын ажлыг үйлдвэрлэгчээс өгсөн заавар зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ..
- 6.4.Гадна заслын материал нь барилга байгууламжийн гадна өнгө төрх, дулаан алдалтыг хязгаарлах, ус уур, чийг нэвтрүүлэхгүй байх, дуу чимээ шингээх, байгалийн давтагдашгүй хүчин нөлөөллөөс хамгаалах зориулалттай. Иймд түгээмэл хэрэглэгддэг материалын нэр төрөл, тэдгээрийн ерөнхий үзүүлэлтүүдийг дурдсан бөгөөд олон улсын болон үндэсний стандартад тусгагдсан материалуудыг урьтал болгон авч үзэв. Гадна заслын ажилд хүснэгт 6.1-д дурдсан материалуудыг голчлон ашиглаж байна.

Хүснэгт 6.1. Гадна заслын материал

МАТЕРИАЛЫН НЭР	ЗОРИУЛАЛТ	ХЭМЖЭЭ	ЗАРЦУУЛАЛТ	ЗУРАГ
Металл хавтан	Барилгад дуу чимээ тусгаарлах, дулаан хадгалах, ус чийг тусгаарлах, фасадын ашиглалтын хугацаа удаан зэрэг давуу талаараа гадна талд ашиглана.	1.22м:5.00м	5-6м ²	
Керамик хавтан	Барилгад дуу чимээ тусгаарлах, дулаан хадгалах, ус чийг тусгаарлах, фасадын ашиглалтын хугацаа удаан зэрэг давуу талаараа гадна талд ашиглана.	0.3м:0.6м	1.8м ²	
Силикон	Чигжээс, зай дүүргэх, дулаан хадгалах, ус чийг тусгаарлах,	590мм	1 м ² -1,5 м ²	
Тэлэгчтэй шруп	Гадна болон дотор заслын материалыг хананд тогтоход хэрэглэнэ	ширхэг	-	
Фасадны эмульс	Гаднын нөлөө бороо усанд тэсвэртэй, барьцалдах чадвар сайтай, нягтаршил өндөртэй, гандалт удаантай өнгөлгөөний материал	1,5кг-15кг	-	
Цавуу	Хөөсөнцрийн цавуу нь барилгын гадна фасадын хөөсийг суурь хананд наах зориулалттай	25кг	-	



Цемент болон хөнгөн дүүргэгч суурьтай цеметэн хавтан	Фасад сэргээн засварлахад хэрэглэнэ	900*2400*12,5	-	
Хар замазк	Фасадын тор, дулаалгын хөөсөнцөр хавтан наахад ашиглана.	25кг	-	



7. ГАДНА ШАВАРДЛАГА, МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

7.1.Шавардлага нь барилгын дулаан хадгалах, дуу тусгаарлах, модон хийцийг өмхрөх ялзрах, шатах, хорхой шавьжнаас хамгаалах, төмөр хийцийг зэврэлтээс хамгаалах, эдэлгээг уртасгах ач холбогдолтой. Барилгын гадна гоёл чимэглэлийн зориулалттай заслын шавардлагад “Терразит шавардлага”-ын төрлийг түлхүү ашиглана.

7.2.Терразит шавардлагыг гүүр ба хөшөө дурсгал түүнчлэн зарим онцлог томоохон барилгын нүүр заслын ажилд хэрэглэхэд тохиромжтой.

Хүснэгт 7.1. Гадна фасадын шавардлагын материал

МАТЕРИАЛЫН НЭР	ЗОРИУЛАЛТ	ХЭМЖЭЭ	ЗАРЦУУЛАЛТ	ЗУРАГ
Шавар	Дулаалгын хөөсөнцөр ба эрдэст хөвөн хавтан зэрэг материалыг гадна хананд наах, түүн дээр хамгаалалтын үе хийх сэргээхэд ашиглана.	25кг/уут	-	
Гадаргууг хөрсжүүлэгч	Ус чийг уумтгай суурь гадаргууд зориулсан хөрсжүүлэгч	10л	0,2л/ м ²	

Хар замаск	Замаск нь цементэн суурьтай, хуурай хольц юм. Барилгын гадна дотор ажилд хэрэглэнэ.	25кг	-	
Чулуун замаск	Бүх төрлийн гадаргууд / бетон болон шавар хана, гипсэн, цементэн хавтан/ бүхий гадаргууд илүү тохиромжтой.	25кг	-	

7.3 ГАДНА ШАВАРДЛАГЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

7.3.1.Барилга байгууламжийн гадна болон дотор шавардлагыг зураг төсөлд заасан тайлбар болон тусгай зориулалтын /хүчил, халуун тэсвэрлэх, ус, хий тусгаарлах, дуу чимээ шингээх гэх мэт/ холбогдох норм ба дүрэм зааврын дагуу гүйцэтгэнэ.

7.3.2.Бэлтгэл үе шатыг хийлгүйгээр шавардлага хийхийг хориглоно.

7.3.3.Заслын ажилд хэрэглэгдэх материал, эдэлхүүн нь улсын стандартын шаардлагыг хангасан байна.

7.3.4.Шохой гипсийн зуурмагаар зөвхөн модон гадаргууг шавардана. Цемент шохойн зуурмагийг бэлтгэхдээ зуурмагийн найрлага нь 1:1:6, 1:2:8 /цемент:шохой:элс/ байвал илүү тохиромжтой. Цементийн зуурмаг нь 1:1 - 1:6 гэсэн харьцаатай байх ба хамгийн тохиромжтой нь 1:3 байна. (БНбД 31-10-05)

7.3.5.Барилгад нийлүүлж байгаа заслын ажлын материалын баглаа боодол дээр таних тэмдэг, заалт маркировки тавигдаагүй буюу боодол нь задарч, эвдэрч хэмхэрсэн үед тэдгээр материал эдлэхүүнийг лабораторийн шинжилгээнд оруулж үр дүн, тохирлын гэрчилгээг үндэслэн хэрэглэж болно. (БНбД 31-10-05)

7.3.6.Заслын ажил нь БНбД 31-10-05-д тусгасан техникийн шаардлагыг хангасан байна.

7.3.7.Заслын ажилд хугацаа дууссан материал ашиглахыг хориглоно

8. БАРИЛГЫН ДОТОР ЗАСАЛ, ЗАСЛЫН МАТЕРИАЛ

Барилгын дотоод өнгө үзэмж нь нарийн мэргэжлийн засалчдын ур чадвар, мэдлэг туршлага болон чанартай материалаас шалтгаалдаг. Чанар стандартын шаардлага хангасан материал хэрэглэх нь эдийн засаг, цаг хугацааг хэмнэнэ.

8.1. ДОТОР ШАВАРДЛАГА, МАТЕРИАЛ

8.1.1.Ердийн шавардлагыг цацах, тэгшлэх, өнгөлөх гэсэн гурван үе давхаргаар гүйцэтгэнэ. Сайн чанарын шавардлагад цацалт ба тэгшилгээг нэг үе хийж эцэст нь өнгө үе тавьсан байх ёстой. Цацах, тэгшлэх үе дээр 1-ээс 2 удаа өнгөн шавардлага

хийж эсвэл өнгөт зуурмагаар чимэглэн шавардсаныг өндөр чанарын шавардлага гэнэ. (БНБД 31-10-05)

8.1.2. Шавардлага нь барилгын дулаан хадгалах, дуу тусгаарлах, модон хийцийг өмхрөх ялзрах, шатах, хорхой шавьжнаас хамгаалах, төмөр хийцийг зэврэлтээс хамгаалах, эдэлгээг уртасгах ач холбогдолтой. Шавардлагын ажлыг чанартай сайн гүйцэтгэх урьдчилан үндсэн гадаргууг бэлтгэх юм. Дотор заслын ажилд хүснэгт 8.1-т тусгасан материалуудыг голчлон ашиглаж байна.

Хүснэгт 8.1. Дотор заслын шавардлагын материал




МАТЕРИАЛЫН НЭР	ЗОРИУЛАЛТ	ХЭМЖЭЭ	ЗАРЦУУЛАЛТ	ЗУРАГ
Гипсэн суурьтай шавар	Гипсэн суурьтай универсал шавардлага. Барилгын дотор хана, таазны тэгшилгээнд ашиглана.	30кг/уут	8,5кг-м ² 10мм зузаантай шавардлага хийх үед	
Чигжээсний шавар	Чигжээсэнд ашиглах шавар. Гипсэн хавтан бетонон гадаргын нөхөөс тэгшилгээ зэрэгт ашиглана.	25кг	0,45кг/ м ²	
Өнгөлгөөний шавар	Барилгын дотор гадна заслын ажил хийхэд зориулагдсан цаг агаарын өөрчлөлтөд тэсвэртэй материал юм.	25кг/уут	-	
Тусгай зориулалтын шавар	Гипсэн хавтан, тусгаарлах материал (пенополистрол болон эрдэс хөвөн хавтан) зэргийг барзгар гадаргуутай тоосго, бетон, шавардлагатай болон сүвэрхэг бетон гадаргуунд наахад хэрэглэнэ	30кг	5кг/м ²	

8.2 ДОТОР ШАВАРДЛАГЫН ТЕХНОЛОГИЙН ШААРДЛАГА

Хүснэгт 8.2.1. Шавардлага хийх технологи

Дотор заслын ажил гүйцэтгэх орчин	Технологийн шаардлага
<p>Температур:</p> <ul style="list-style-type: none"> Гадна орчин – 8° С -аас бага нөхцөлд дотор заслын ажлыг өрөөний температур +10° С-ээс дээш байна. 	<p>Шавардлагыг 3 үе давхар хийнэ</p> <ul style="list-style-type: none"> дэвсгэр үе, тэгшилгээ үе, өнгө үе
<p>60%-аас илүү чийглэгтэй нөхцөлд орших / халуун ус, угаалгын газар, нойтон технологиор ажиллах цех гэх мэт /хаяавч, хашлага, ирмэг зэрэг байнга чийгтэй байх барилгын ханын гадагшаа товойж гарсан хэсгүүдийг шавардахдаа трепел, тоосгоны нунтаг болон бусад төрлийн усанд тэсвэртэй нэмэлт хольцыг хэрэглэх ба цементэн зуурмагт зөвхөн портланд цементийг хэрэглэнэ.</p>	<p>Шавардлагын үе тус бүр нь дараагийн үеийн дэвсгэр болж, бат бэхээр тогтоох нөхцөлийг бүрдүүлэх ёстой.</p>
<p>Тоосго чулуу, бетон гадаргууг тоос, шороо, наалдац, тосон толбо, хар тос зэргээс сайтар цэвэрлэж гадаргуугийн түшингээс илүү гарсан хэсгийг өөлж тэгшилсэн байх ёстой.</p> <p>+23С 0 -ээс дээш температуртай цаг агаарын нөхцөлд тоосгон гадаргууг заавал ус цацан чийглэж зуурмагийн усыг өөртөө шингээхгүй болгох хэрэгтэй.</p>	<ul style="list-style-type: none"> Дэвсгэр үеийн шавардлагын зузаан нь шохой ба шохой-гөлтгөнийн зуурмагт 7 мм, цементэн зуурмагт 5 мм-ээс хэтрэхгүй, Шавардлагын нийт үеийн зузаан <ul style="list-style-type: none"> – энгийн шавардлагад 12 мм, – сайн чанарын шавардлагад 15 мм, – өндөр чанарынхад 20 мм-ээс хэтрээгүй байна.
<p>Өвлийн улиралд хийгдэх орон сууц, олон нийтийн барилгын дотор заслын ажлыг салхивч, төвийн халаалтын системийг байнгын ажиллагаатай нөхцөлд хийнэ. Шаардлагатай үед түр халаалт салхивчийг нэмж ажиллуулж болно. Энэ үед 1 цагт 2-оос 3 удаа агаарыг сэлгэх нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой. Өрөө тасалгааны цонх хаалганы нүхийг атмосферийн үйлчлэлээс хамгаалсны дараа ердийн салхины үйлчлэлээр хатааж болно. Ил задгай гал, түр зуухыг хатаалгад хэрэглэхийг хориглоно.</p>	<p>Механикжсан аргаар шавардлага хийж байгаа үед зуурмагийн хөдөлгөөнт чанарыг стандартын конусаар шалгахад цацалтын үеийн зуурмаг 9см-ээс-14 см, тэгшлэх үеийнх 7см-ээс 8 см, өнгөн үе гөлтгөнөтэй бол 9 см-ээс 12 см, гөлтгөнөгүй бол 7 см-ээс 8 см байна.</p>
	<p>БНБД 31-10-05-д тусгасан техникийн шаардлагыг хангасан байна.</p>

8.3. ШАВАРДЛАГЫН АЖЛЫН ҮЕ ШАТ

	<p>Нэгдүгээр үе буюу дэвсгэр: Гадаргууд зуурмагийг цацаж, нялж тогтоохыг дэвсгэр үе гэх ба цацах, нялах 2 аргаар гүйцэтгэнэ. Дэвсгэр үе нь гадаргуугийн нүх сүв, хонхор, хотгор, өө сэвийг арилгах, барзгар болгох, барьцалдах чанарыг сайжруулах зорилгоор хийнэ. Зуурмагийн конусын живэлт 8-12 см шингэвтэр байна. Шавардлагын үеийн зузаан нь 3-5 мм байна.</p>
	<p>Хоёрдугаар үе буюу тэгшлэх: Шавардлагын үндсэн хэсэг бөгөөд цацсан зуурмагийг шууд тэгшлэх, булан ирмэг гаргах, хонхор гүдгэрийг тэгшилнэ. Зуурмаг нь 7-9 мм-ийн конусан живэлттэй байх ба шавардлагын үеийн зузаан нь 5-7мм байна. Энгийн шавардлагыг цацах, тэгшлэх 2 үеэр хийнэ.</p>
	<p>Гуравдугаар үе буюу өнгөлгөө: Сайн чанарын шавардлагыг дэвсгэр, тэгшилгээ, өнгө үеэр шавардана. Тэгшилгээ хийсэн гадаргуугийн барзгарыг арилгаж, жигд гөлгөр болгох, ирмэг буланд нарийн засал хийх, будгийн ажлын дэвсгэр үе болгох зорилгоор өнгөн үеийн шавардлагыг хийнэ. Зуурмагийн найрлага нь 60%-ийн устай 12см конусын живэлттэй 1,5мм-ийн нүхтэй торонд шигшсэн цөцгий маягийн шингэн зуурмаг байна. Шавардлагын зузаан нь 2мм-ээс хэтрэхгүй байна.</p>

8.3.1. Шавардлагын хүлцлийн алдааг хүснэгт 8.2-т үзүүлэв. (БНБД 31-10-05)

Хүснэгт 8.2. Хуудсан материалаар өнгөлсөн буюу шавардсан гадаргуугийн хүлцэл

Гадаргуугийн нэр,шугамын элементүүд	Өнгөлгөөний хүлцэл		
	Ердийн Сайн чанарын Дээд зэргийн	Ердийн Сайн чанарын Дээд зэргийн	Ердийн Сайн чанарын Дээд зэргийн
2 м-ийн урт шугам буюу тэгшлүүрээр шавардсан гадаргууг дарж үзэхэд мэдэгдэх тэгш байдал	Хотгор буюу гүдгэрээрээ 5мм-ээс ихгүй 3-аас цөөнгүй гүдгэр	Хотгор буюу гүдгэрээрээ 3 мм-ээс ихгүй 2-аас цөөнгүй гүдгэр	Хотгор буюу гүдгэрээрээ 2 мм-ээс ихгүй 2-оос цөөн
Ханын гадаргуугийн босоо ба /таазны/ хэвтээ чиглэлийн тэгш байдал	Тасалгааны нийт өндөрт /уртад/ 15 мм	1 м өндөрт 1 мм, тасалгааны нийт өндөрт /уртад/ 10 мм-ээс ихгүй	1м өндөрт 1мм тасалгааны нийт өндөрт /уртад/ 5 мм-ээс ихгүй

өнцөг,булан,цонх,хаалганы амалгаа,тал багана, баганын хэвтээ ба босоо чиглэлийн алдац	Бүх элементэд 10 мм	1м өндөрт буюу уртад 1 мм буюу бүх элементэд 5мм-ээс ихгүй	1м өндөрт буюу уртад 1 мм буюу бүх элементэд 3мм-ээс их биш
Гурви ба муруй гадаргуугийн радиусын зөрүү	10мм	7мм	5мм
Цонх хаалганы шавардсан өргөн нь төслөөс зөрөх зөрүү	Шалгагдахгүй	3мм	2мм
Өнцөг, булангийн хоорондох гурвийн босоо ба хэвтээ чиглэлийн зөрүү	6мм	3мм	2мм

8.4 ШАВАРДЛАГЫН АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Бэлэн болсон Шавардлагын ажлыг хүлээн авахад доорх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шалгаж хүлээж авна.

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Шавардлага нь үндсэн гадаргууд бат бэх наалдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гадаргуугийн шавардлага тэгш, гөлгөр,ирмэг булан нь тэгш шулуун эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Урсалт,толбо хужир ургасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Өнгөт шавардлагын уулзваруудыг ялгаж шугамаар заагласан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Ан цав, бүдүүн ширхэгтэй, барзгар,овойж гарсан согогтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Ил болон далд ажлыг зургаар баталгаажуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

9. ЦЕМЕНТ

Цемент нь хатахдаа агаар дахь нүүрсхүчлийн хийтэй урвалд орж хатуурсан хэсгүүдийг барьцалдуулагч материал юм. Цемент нь MNS 974:2008 ПОРТЛАНД ЦЕМЕНТ техникийн шаардлага хангасан байна. Мөн төрөл бүрийн шавардлага, зуурмаг бэлтгэх, заслын ажилд хэрэглэхдээ MNS 347:2002 барилгын болон технологийн хэрэгцээний шохой техникийн шаардлага хангасан байна.

10. ЭЛС

Элсийг чанарын стандарт үзүүлэлт (ширхгийн бүрэлдэхүүн, тоосорхог ба шаварлаг хэсэг байгаа эсэх)-ээс хамаарч хоёр ангилалд хуваана. Барилга байгууламжийн бүтээц, заслын ажилд хэрэглэх элс нь MNS 0392:2014 “Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс” техникийн шаардлага хангасан байна.

11. ӨНГӨЛГӨӨ БА ТЭГШИЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ


11.1. Барилгын гадна, дотор өө сэвийг дарж, тэгшилгээ, өнгөлгөө хийхэд зориулсан материалуудыг хэлнэ. Өнгөлгөө тэгшилгээний материал нь хаана юунд хэрэглэхээс шалтгаалж маш олон төрөл байдаг. Иймд тус ажлыг гүйцэтгэхэд материалын

чанар, засалчдын ур чадвар ихээр шаарддаг. Өнгөлгөө тэгшилгээний ажилд ихэвчлэн рек, лазер ашиглаж алдааг шалгана.

11.2. Шавардлагын ажилд хэрэглэгдэх материалууд нь гадаргууг тэгшлэх өө сэвийг дарах зориулалттай учир өнгөлгөө, тэгшилгээний ажилд ашиглаж болно. Өнгөлгөө тэгшилгээний ажилд хүснэгт 11.1-д дурдсан материалуудыг голчлон ашиглаж байна.

Хүснэгт 11.1. Өнгөлгөө тэгшилгээний материалууд

МАТЕРИАЛЫН НЭР	ХЭРЭГЛЭЭ	ХЭМЖЭЭ	ЗАРЦУУЛАЛТ	ЗУРАГ
Шал тэгшлэгч	Шалны гадаргууг өөгүй тэгш, ус нэвтрүүлэхгүй байлгах зорилгоор хэрэглэнэ.	25кг	-	
Хар замаск	Ханын тэгшилгээний эхний үед ашиглана.	20кг	-	
Угаадаг замаск	Ханын өнгөлгөө тэгшилгээнд ашиглана. Барьцалдах чанар сайн, агаар нэвтрүүлдэг, хагарч цуурахгүй, цавуутай хольж хэрэггүй, усаар зуурч шууд хэрэглэж болно.	20кг	-	
Хар замаск	Барилгын дотор ханын гадаргууг тэгшлэх, гадна ханын дулаалгын хөөсөнцөр хавтан наах зориулалттай, гадна болон доторх засал чимэглэл хийхэд нэн тохиромжтой.	25кг	-	
Шал өнгөлгөгч	Байгалийн чулуун шал, гантиг чулууг өнгөлөхөд хэрэглэнэ	5кг	-	

Гипсэн хавтан	Тасалгааны хамар хана, ханын өнгөлгөө, дүүжин тааз гал түймрээс хамгаалах хийц зэрэгт хэрэглэнэ.	1.2м*2.5м*0.08м -1.2м*2.5м*0.12м	3м ²	
---------------	--	-------------------------------------	-----------------	---

12. ЗАМАСК

Дотор заслын өнгөлгөө тэгшилгээнд ашиглах замаск нь MNS 5526 2005 Барилгын заслын ажилд хэрэглэх замаск Техникийн шаардлага, MNS 6424 2013 Барилгын ажилд хэрэглэх цавуу. Техникийн шаардлага, MNS 5079 2001 Үйлдвэрийн эрүүл ахуйн шаардлагуудыг хангасан байна.

12.1. ЦАГААН ЗАМАСКААР ДОТОР ЗАСЛЫН ӨНГӨЛГӨӨ ТЭГШИЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ

- 12.1.1.Бэлтгэл ажил: Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал хангасан зориулалтын ажлын хувцас өмсөнө. /гутал, бээлий амны хаалт, малгай гэх мэт/
- 12.1.2.Гадаргууг шалгах: Технологийн шаардлага нь гадаргуу тэгш, гадаргуу гөлгөр, тоосжилтгүй байна. Гадаргуугийн алдааг тэгшилж цэвэрлэнэ. Рек ашиглан алдааг тогтооно.
- 12.1.3.Замаск 1-р үе тавих: Гадаргуугийн хонхор хэсгийг дүүргэх. Замаск зуурахдаа ус, 107 цавууг 1:3 харьцаатай хольж зуурна. Төмөр татагчаар жигд нямбай татна. Хэмжин шалгахдаа тавигдсан шаардлагын дагуу шалгана.
- 12.1.4.Замаск 2-р үе тавих: Гадаргууг жигд татах булан ирмэг дээр рек барьж хийх ба таазны замаскийг 3 үе татна. Хэмжин шалгахдаа тавигдсан шаардлагын дагуу шалгана. Хүлцэх алдаа 2метр тутамд 1-3мм байна.
- 12.1.5.Зүлгүүр хийх: Өрөөний цонхнуудыг хааж харанхуй орчинд гэрэл тусган зүлгэж гөлгөр гадаргуутай болгоно.
- 12.1.6.Гадаргууг цэвэрлэх: Тоосжилтыг зөөлөн үстэй шүүрээр цэвэрлэнэ.



12.2. ӨНГӨЛГӨӨ, ТЭГШИЛГЭЭНИЙ АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Бэлэн болсон өнгөлгөө, тэгшилгээний ажлыг хүлээн авахад дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шалгаж хүлээж авна.

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Шавардлага нь үндсэн гадаргууд бат бэх наалдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гадаргуугийн шавардлага тэгш, гөлгөр, ирмэг булан нь тэгш шулуун эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Урсалт, толбо хужир ургасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Өнгөт шавардлагын уулзваруудыг ялгаж шугамаар заагласан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Ан цав, бүдүүн ширхэгтэй, барзгар, овойж гарсан согогтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Ил болон далд ажлыг зургаар баталгаажуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хиймэл хавтанцраар өнгөлгөө хийсэн үед хавтанцруудын хоорондох заадас тэгш эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Өнгөлөгдсөн бүтээцийн гадаргуу хавтанцар хоёрын хооронд завсар, хөндийгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Гадаргууд 2 м-ийн урттай шугам тавьж шалгахад 2 мм-ээс илүү завсар гарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Хавтанцруудын захын эмтэрхий 0.5 мм-ээс их гарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Өнгөлгөө хийсэн гадаргууд зуурмаг урссан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

13. ХАНЫН ЦААС



13.1. Ханын цаас буюу обойг шинж чанараар нь:

- Ердийн
- Чийгэнд тэсвэртэй
- Угаадаг
- Дуу шингээдэг,
- Дулаан тусгаарладаг,
- Галд тэсвэртэй,

Материалын төрөлөөр нь:

- Нийлмэл материалаар хийсэн
- Шилэн хөвөн обой,
- Шингэн обой






13.2 Ихэнх ханын цаасны хэмжээ ойролцоо ба өргөн нь 0,52-0,56м, урт нь 10-10,5м байх ба ойролцоогоор 5м² талбайг өнгөлөн наана. Шилэн хөвөн обой нь 1м-н өргөнтэй, 5м-ийн урттай байх ба удаан эдэлгээтэй. Нэг боодол шилэн хөвөн обойгоор 50м² талбайг бүрэх боломжтой. Ус чийг тэсвэрлэдэг цаасны ашиглалтын хугацаа 6-10 жил байдаг бол энгийн цаасных 3-4 жил байдаг.

13.3. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

13.3.1.Ханыг өө сэвгүй, алдаагүй тэгшилж, өнгөлж бүрэн дууссаны дараа ханын цаасыг наах шаардлагатай;

13.3.2.Ханын цаас наах зориулалтын цавууны шингэрүүлсэн уусмалаар ханыг хөрсжүүлэх;

13.3.3.Хуучин цаасан өнгөлгөөтэй гадаргуу байвал дараах үе шатуудаар гадаргууг бэлтгэнэ. Үүнд:

№	Үе шатны нэр	Тайлбар	Зураг
1	Хуучин өнгөлгөөг хуулах	Ханын төрөл хэлбэрээс үл хамааран хуучин өнгөлгөө, будгийг нийтэд нь хуулах	
2	Эхний үеийн хөрсжүүлэг хийх	Хуучин өнгөлгөөг хуулсны дараа гадаргууг тоос шорооноос цэвэрлэж хөрсжүүлэг буюу грунтыг гадаргууд түрхэнэ. Энэ нь гадаргууг тогтвортой болгож, чийг шингээх чадваргүй болно.	
3	Ханын гадаргуугийн гэмтэл согог, хагарлыг арилгах	Ханын өө сэв, хотгор, хагарлыг арилгахын тулд бэлэн хуурай хольцоор хэсэгчлэн засвар хийх	
4	Тэгшилгээ хийх	Өнгөлгөө хийхээс өмнө гадаргууг нийтэд нь замаскаар тэгшлэх нь чухал ажилбар юм. Үе болгоны дараа зүлгэлтийг зүлгүүрийн гар ашиглан зүлгүүрээр хийнэ.	
5	Давтан хөрсжүүлэг хийх	Энэ үеийг хийснээр ханын цаасны наалдах чадвар сайжирдаг ба удаан эдэлгээтэй болгоход чухал нөлөө үзүүлнэ.	

13.3.4.Ханын цаас наахдаа зориулалтын, чанарын шаардлага хангасан цавуу ашиглана;

13.3.5.Цавууг савлагаа дээрх зааврын дагуу бэлтгэх;


13.3.6.Хүний биед харшил үүсгэхгүй, элдэв хурц үнэргүй, чанарын болон тохирлын гэрчилгээтэй байх шаардлагатай;

13.3.7.Ханын цаас наах ажил хийгдэж дууссаны дараа тогтмол 100 С-аас багагүй температурт байлгавал зохино.

13.3.8.Барилгад нийлүүлж байгаа заслын ажлын материалын баглаа боодол дээр таних тэмдэг, заалт маркировки тавигдаагүй буюу боодол нь задарч, эвдэрч хэмхэрсэн үед тэдгээр материал эдлэхүүнийг лабораторийн шинжилгээний үр дүнг, тохирлын гэрчилгээг үндэслэн хэрэглэж болно.

13.4. ХАНЫН ЦААС НААХ ТЕХНОЛОГИ

13.4.1.Ханын цаасыг цонх хаалганы байршлаас хамааран гарах хаалга, үүд рүү чиглэлтэйгээр наана. (Зураг 13.1)



Зураг 13.1. Ханын цаас наах дараалал

13.4.2.Ханын цаас наахаас өмнө хуурч унахаас сэргийлэх, гологдол гаргахгүйн тулд бүх цонх, хаалгыг хаах шаардлагатай;

13.4.3.Цавууны уусмал бэлтгэхдээ гадна талдаа хэмжээстэй тунгалаг хувин ашиглах нь тохиромжтой. Тасалгааны температурт тусгайлан бэлтгэсэн усан дээр цавуугаа хийж цахилгаан хутгагчаар уустал нь тасралтгүй хутгана. Цавууны уусмалыг хөөж тэлтэл нь хэсэг хугацаагаар амраана.


13.4.4.Нийт хананд хэдэн босоо обой орохыг тооцоолно. Үүний тулд хананы уртыг хэмжиж, уртын хэмжээг ханын цаасны өргөнд хуваана. Мөн ханын өндрийг хэмжиж, хэдэн боодол обой орохыг тооцоолон зүснэ. Зүсэлт хийхдээ нямбай хандах ба төмөр шугам, цаасны хутга ашиглана. Нэг хананд шаардагдах обойг зүсэж авсны дараа доош нь харуулж тавина.

13.4.5.Хананы цаасыг зүсэж бэлтгэсний дараа багс, өнхрүүлгийг цавуунд дүрж цаасны чанх голоос үзүүр хүртэл эн тэнцүү хэмжээгээр цавуугаа түрхэнэ. Зарим хэсэгт нь зузаан, заримд нь нимгэн түрхэж болохгүй. Цавуу түрхсэн ханын цаасаа үзүүрээс нь дотогш 2:1 харьцаагаар нугална. Цавууг ханын цаасны нүүрэн тал руу урсгаж болохгүй. (Зураг 13.2)



Зураг 13.2. Ханын цаасны цавуу түрхэх

- 13.4.6.Ханын цаас цонхон талын булангаас эхлэн наах ба булан алдаатай байвал эхний цаасыг наахын тулд харандаа, тэгш ус эсвэл лазер хэмжигчийн тусламжтай хананы эгц хажуу талд нь босоо тэмдэглэгээ хийнэ. Ханын дээд талд таазанд тулгаж наахгүй 5см орчим зай үлдээж хэвтээ шугам татна.
- 13.4.7.Ханын цаас наах ханын гадаргууг цавуудаж эвхэж тавьсан цавуудсан обойг зүүн гаран дээрээ тохож тавин баруун гараараа дээд талаас нь эхлэн аяархан хуулж обойг шугамын дагуу байрлуулж дээрээс доош нь, дундаас нь хоёр үзүүр рүү шпателийн тусламжтай наахдаа хана ба цаасны хоорондох агаарыг шахан гаргаж аль болохоор хий оруулахгүй нямбай наах хэрэгтэй.
- 13.4.8.Цавуудаж бэлэн болсон хоёр дахь босоо ханын цаасыг эхний обойн ирмэгт тулгаж наана. Шалны хөвөөнөөс илүү гарсан цаасыг цаасны хутгаар зүсэж авна. Ийм маягаар шулуун хананы обойг нааж дараа нь булангийн обойг тааруулан зүсвэр хийж наана.



Зураг 13.3. Ханын цаас наах технологи

- 13.4.9.Цонхны дээд талд тохирох хэмжээгээр цаасыг зүсэж шпателийн тусламжтай наана. Цонхны тавцан орчмын хананд цаас наахад нэлээд анхаарал шаардана. Эхлээд тавцангийн хананаас түрж гарсан хөндлөн хэсгийн хэмжээнд тохируулан цаасыг өөлж авсны дараа эгц дээш нь хайчилна. Халаах хэрэгсэл буюу паар, цонхны тавцан хоорондын зайг юуны өмнө хэмжинэ. Хаалганы дээд талд тохирох хэмжээний цаас зүсэж, хана, хүрээ мод хоёрын дунд зааг гаргалгүйгээр сайн тэнийлгэж наана. Унтраалга, розетка орчмын ханыг цавуудахын өмнө цахилгааныг салгасан нь илүү найдвартай. Унтраалгыг ил гаргахын тулд тэр орчмын цаасыг тоонолжин хээ гарган хайчилна.
- 13.4.10.Ханын цаас наасны дараа зарим газар хөндийрч товойж харагддаг. Тариурт цавуу соруулж тэрхүү хөндий хэсэгт шахна. Хөндий цавуугаар дүүрэнгүүт гадна талаас нь гараараа нямбай гэгч нь илж наалдуулна.

13.5. АНХААРАХ ЗҮЙЛС

Ханын цаас наахдаа цавууг ханын цаасныхаа өнгөн хэсэг дээр хүргэхгүй байх хэрэгтэй. Зааг залгаасыг давхцуулахгүй цэвэрхэн хийх хэрэгтэй. Зүсэлтийг сайн хэмжиж, материалын хорогдол гаргахгүй тооцож хийх нь чухал. Зүсэгч хутганы ир маш сайн байх хэрэгтэй. Цавууны өтгөн шингэнийг тааруулж, хэт зузаан биш жигд түрхэнэ. Шингэн обойг жигд гадаргуугаар, өө сэвгүй нялах хэрэгтэй.

13.6. ХАНЫН ЦААС НААХ АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Бэлэн болсон өнгөлгөө, тэгшилгээний ажлыг хүлээн авахад доорх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шалгаж хүлээж авна.

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Ханын цаасыг наахдаа ирмэг буланг дутуу наасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Зүсвэрийг зөв тооцож хээ угалзыг тааруулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Наах явцад ханын цаас урагдаж цоорсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Ханын дээд талд таазанд тулгаж наахгүй 5см орчим зай үлдээсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Зааг залгаасыг давхцуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Ханын цаас наасны дараа зарим хэсгүүдэд хөндийрч товойсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

14. БУДАГ

14.1.1.Будгийн ажил нь барилга байгууламжид өнгө нэмэх, гадаргууг байгалийн болон механик гэмтлээс хамгаалах зэрэг давуу талтай. Будгийг гоёл чимэглэлийн заслын ажилд ашиглана. Үүнд:

Өнхрүүлэг ба цоолбороор хээ тавих, эмжээр шугам татах, үндэсний хээ угалз, цоохортуулах зэрэг ажилбарууд багтана.

14.1.2.Будгийн ажлыг хийж гүйцэтгэхдээ MNS 4583:2003 Тосон будаг. Техникийн шаардлага, MNS 5252:2003 Барилгын ажилд хэрэглэгдэх цийдмэг будаг Техникийн шаардлага стандартын шаардлага хангасан будаг ашиглана.

14.2. ТОСОН БУДАГ



14.2.1.Дан олифоор найруулсан будгийг тосон будаг гэнэ. Тосон будаг барилгын үйлдвэрлэл засварын ажилд өргөн хэрэглэгдэнэ. Тосон будгийн найрлагаар модон материал, шавардлага хийсэн гадаргууг будна.

14.2.2.Модон хийцийг ус чийгний нөлөө, ялзаралт, өмхөрөлтөөс, металл хийцийг зэврэлтээс хамгаална. Тосон будгийн үндсэн материал нь өтгөн тосон будаг, холбогч нь олиф, туслах материал нь хатаагч юм. Будгийн гялгар өнгийг бууруулж, бүрсгэр болгох зорилгоор хуурай будгийн зүйл хольж найруулдаг.

- 14.2.3. Тосон будаг бэхжих явцдаа эдэлгээтэй, тэсвэртэй, өөрийн эзлэхүүнийг өөрчлөхгүй байх ёстой.
- 14.2.4. Тосон будаг нь 200С температурт 24 цагийн дотор хатна. Өрөө тасалгаа хүйтэн байх тутам будгийн хаталт удааширна.
- 14.2.5. Бороотой буюу чийгтэй үед мөн 80С-с бага температурт будгийн ажил хийхийг хориглоно.

14.3. ЛАК



Барилгын гадаргууг агаарын нөлөөнөөс, төмөр бүтээцийг зэврэлтээс, модон бүтээцийг илжрэлт ялзралт, элэгдэхээс хамгаалахаас гадна ариун цэвэр, эрүүл ахуй, гоо зүйн шаардлага, галын аюулаас хамгаалах зорилгоор лакийг хэрэглэнэ.

Тосон ба лакан будагт гадаргууг бэлтгэхэд гадаргуугийн төрлөөс хамаарч дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

Хүснэгт 14.1. Будгийн гадаргууг бэлтгэх

№	Үе шат	Үйл явц	Зураг
1	Шавардсан ба бетон гадаргууг бэлтгэх	Гадаргууг цэвэрлэж, хагархай, ан цавыг засаж, өнгөлсний дараа гадаргууд хөрсжүүлэлт хийнэ.	
2	Модон гадаргууг бэлтгэх	Бүтээц дээр наалдсан тоос шороо, шавар зуурмагийн толбо зэргийг хусаж зүлгүүрдэж цэвэрлэх ба ан цав үүсэж, хагарсан, заадас нийлсэн хэсэгт завсар гарч, муу нийлсэн, модны яр зэргийг хэсэгчилэн солих, зай завсрыг нийлүүлж шахаж хадаж тогтоох.	
3	Метал гадаргууг бэлтгэх	Бүтээцийг будхын өмнө гадаргууд наалдсан тоос шороог зүлгэн цэвэрлэж, гагнуурын шаваас болон тогтсон зэвийг сайтар цэвэрлэнэ.	

14.4. ЦАВУУН БУДАГ

Цавуун будаг нь усанд тэсвэргүй учир орон сууц, олон нийтийн барилгын өрөө тасалгааны дотор талын хана таазыг будахад хэрэглэнэ.

14.3.1. Аюулгүй ажиллагааны шаардлага:

14.3.1.1. Будгийг үйлдвэрлэх, хэрэглэх, турших ажлын байр нь агаар сэлгэх төхөөрөмжөөр тоноглогдсон системтэй байна.

14.3.1.2.Будагтай ажиллагсад нь ажлын тусгай хувцас, гутал, бээлий, амны хаалт, нүдний шилээр хангагдсан байна.

14.5. БУДГИЙН АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Бэлэн болсон будгийн ажлыг хүлээн авахад доорх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шалгаж будсан гадаргуугийн будаг гүйцэд хатсаны дараа хүлээж авна.

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Толбо, урсалт, өөр өнгөөр шүршсэн, будаг үсэргэсэн, цавуу нь багадаж сааралтсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Багсны мөр гарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Тосон ба нийлэг, паалант, лакан будгаар будсан гадаргуу нь нэгэн жигд өнгөтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Ул будгийн үе нэвт гэрэлтсэн,толбо гарсан, үрчийсэн, атираа суусан, будалгүй үлдээсэн, будгийн хальс наалдсан, бүрзийсэн,хонхор,гүдгэр болсон,багсны мөр гарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Хоёр өөр өнгөөр будагдсан, гадаргуугийн нийлсэн уулзварт бие биедээ будаг нэвчсэн,хязгаарын шугамаас давсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Будгийн эмжээр шугам, хүрээ,зах нэгэн жигд өргөнтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Өнхрүүлэг ба зөөлөн резин хэвээр хээ тавьсан гадаргуугийн засал нэгэн жигд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Хээ тавилгүй үлдээсэн,толбо гарсан, шугамаас мурийсан, будаг урсаж зураг мэдэгдэхгүй ойлгогдохгүй болсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

15. САВАЛГАА, ХАДГАЛАЛТ ТЭЭВЭРЛЭЛТ

Материалын үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа, чанарын гэрчилгээг уут, саван дээр заавал тусгасан байна. Үйлдвэрлэсэнээс хойш 60 хоногийн дотор хэрэглэхээр тооцож хадгална. Материалын зориулалт, хэрэглээнээс хамааран 1-50кг хүртэл ус нэвтрэхгүй цаасан болон нийллэг уут, хуванцар саванд хийсэн савалгаатай байна.

Төрөл ангилал, бат бэхийн ангиар хольж хураах, чийг авхуулах, гадны зүйлээр бохирдуулах, задгай ил агуулахад хадгалахыг хориглоно.

Төрөл бүрийн тээврийн хэрэгсэлээр тээвэрлэж болно.



- 1) Үйлдвэрлэгчийн лого, барааны тэмдэг,
- 2) Үйлдвэрлэсэн он сар
- 3) Материалын төрөл
- 4) Шинж чанар, бат бэхийн анги /PC-42.5, OPC-42.5 гэх.мэт/
- 5) Савлагаанд хамаарах цементийн дундаж цэвэр жин
- 6) Стандартын тэмдэглэгээ (MNS 974 : 2008 гэх мэт)
- 7) Хадгалах хугацаа хадгалах нөхцөл
- 8) Үйлдвэрлэгчийн хаяг, утас

Хүснэгт 15.1. Материалын хадгалах нөхцөл

ХАДГАЛАХ НӨХЦӨЛ	ЦЕМЕНТ	ЭЛС	ЗАМАСК	БУДАГ
Хуурай чийггүй	✓	✓	✓	✓
Дотор хадгалах	✓	✓	✓	✓
Нарны тусгалаас хамгаалах	✓	✗	✓	✓
45см-ээс дээш өндөрт Ул тавиур ашиглах	✓	✓	✓	✗
Савалгаа	✓	✓	✓	✓
Төрөл ангилалаар хураах	✓	✓	✓	✓
2-3 давхар полиэтилен уутыг ашиглан савлаж хадгалах	✓	✗	✓	✗
Хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг холбогдох норм дүрэм, стандартын дагуу шалган шаардлага хангасан тохиолдолд дахин хэрэглэж болох	✓	✓	✓	✗



Зураг 15.2. Заслын материалыг агуулахад хадгалах

Хадгалах нөхцөл:		Сануулах тэмдэг:				
Нарны тусгалаас хамгаалах	Чийгнээс хамгаалах	Дуулга малгай (каска өмсөх)	Ажлын хувцас өмсөх	Бээлий өмсөх	Нүдний шил зүүх	Амны хаалт хэрэглэх
						Зөөсний дараа гар нүүрээ угаах

Зураг 15.3. Материалын савлагаан дахь сануулах тэмдэг тэмдэглэгээ

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. MNS 0392:2014 “Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс”
2. MNS 6424 2013 “Барилгын ажилд хэрэглэх цавуу”
3. MNS 5526 2005 Барилгын заслын ажилд хэрэглэх замаск. Техникийн шаардлага
4. MNS 3091:2008 “Цемент техникийн ерөнхий шаардлага”
5. MNS 0974:2008 Портландцемент “Техникийн шаардлага”
6. MNS 4583:2003 Тосон будаг. Техникийн шаардлага ба турших арга
7. MNS 5079 2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрийн эрүүл ахуй. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
8. MNS 5252:2003 Барилгын ажилд хэрэглэх цийдмэг будаг. Техникийн шаардлага ба турших арга
9. БНБД 31-10-05 Заслын ажил
10. <https://www.facebook.com/KnaufMGL>

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар